ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 01 сарын 20 өдөр Дугаар А/03 Даланзадгад

Сувилахуй, тусгай мэргэжлийн тусламж үйлчилгээг хөгжүүлэх 2022 оны аймгийн төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 заалтыг үндэслэн, хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Сувилахуй, тусгай мэргэжлийн тусламж үйлчилгээг хөгжүүлэх 2022 оны аймгийн төлөвлөгөө"-г хавсралтаар баталсугай.
2. Төлөвлөгөө хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг байгууллагын болон орон нутгийн төсөв, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын хандив тусламжийн хүрээнд шийдвэрлэж ажиллахыг Удирдлага төлөвлөлт, санхүүгийн хэлтэс (М.Цэндсүрэн), эрүүл мэндийн байгууллагуудын захирал, дарга нарт үүрэг болгосугай.
3. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйгээр хангаж, хугацаанд нь тайлагнаж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс (Ж.Отгонбайгал), Сувилахуйн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн (А.Мөнхтуяа) нарт үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтэс (Б.Мидэрсүрэн)-д даалгасугай

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Г.ШИЖИРТУЯА

4619267282
ТУ31732 9047751

My computer 2021 tushaal

Эрүүл мэндийн газрын даргын
2022 оны 01 сарын 20 -ны өдрийн
А/03 дугаар тушаалын хавсралт

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН СУВИЛАХУЙ , ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

**ЗОРИЛГО:** Сувилагч, тусгай мэргэжилтнүүдийн үйл ажиллагаанд тулгамдсан асуудлыг бүх талуудын оролцоог ханган эрүүл мэндийн байгууллага, аймгийн өвөрмөц нөхцөл, нийгэм, эдийн засгийн байдалтай уялдуулан тодорхойлж, шийдвэрлэх

**ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭ :** Өмнөговь аймгийн нийт эрүүл мэндийн байгууллагууд, сувилагч тусгай мэргэжилтнүүд
Орон нутгийн удирдлагууд болон Эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал дэмжлэг үзүүлж ажиллана.

| № | Үйл ажиллагаа | Бүтээгдэхүүн | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилтийг хариуцах байгууллага, албан тушаалтан | Хамтран хэрэгжүүлэх албан тушаалтан | Хэрэгжих хугацаа | Санхүүгийн эх үүсвэр |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Үйл ажиллагааны чиглэл I** | | Нийгмийн эрүүл мэнд | | | | | |
| | ***НЭМ-ийн сувилахуйн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх*** | | | | | | |
| 1.1 | 1. Нийгмийн эрүүл мэндийн сувилахуйн тусламж үйлчилгээг хөгжүүлэхэд сувилагч,тусгай мэргэжилтний гүйцэтгэх үүргийг өргөжүүлэх | Зохион байгуулсан арга, хэмжээний тоо, төрөл | Иргэдийн эрүүл мэндийн боловсрол нэмэгдэж амьдралын чанар сайжирна. | ЭМБ-ууд НЭМ-ийн ажилтан | ЭМГ | Жилийн турш | ЭМБ-ууд зардлыг хариуцах |
| 1.2 | 2. Өсвөр насны хүүхэд залуучуудын эрүүл мэнд чиглэсэн урьдчилан сэргийлэх мэдлэг боловсролыг олгох олон талт үйл ажиллагаар зохион байгуулах | Зохион байгуулсан арга хэмжээ | Өсвөр насныхны эрүүл мэндийн боловсрол нэмэгдэнэ. | ЭМБ-ууд Өсвөр үеийн кабинет | ЭМГ | Жилийн турш | ЭМБ-ууд, хамтран ажиллах байгууллагууд |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.3 | 3.Сувилахуйн дагнасан тусламж үйлчилгээ үзүүлэх, зөвлөгөө өгөх,өдрийн “Сувилахуйн төв” -г орон нутагт байгуулан ажиллуулахад дэмжин туслах , арга зүйгээр хангах , хөгжүүлэх | Авсан арга хэмжээ | “Сувилахуйн төв” -ийн үйл ажиллагаа тогтвортой явагдана. | Сувилахуйн ТТБ | ЗДТГ<br>НБХ<br>ЭМГ | Жилийн турш | Сувилахуйн төв |
| 1.4 | 4.Гэрээр үзүүлэх сувилахуйн тусламж үйлчилгээний төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх чанарыг сайжруулах | Авсан арга хэмжээ | Гэрийн нөхцөлд хийгдэх асаргаа, сувилгааны заалтын дагуу үйлчлүүлэгчид сэтгэл санаа, орчин, нөхцөл тав тухтайгаар тусламж үйлчилгээг авна. | ЭМБ-ууд | ЭМГ | Жилийн турш | ЭМБ-ууд зардлыг хариуцах |
| 1.5 | 5.Цахим Өмнөговь хөтөлбөрийн хүрээнд иргэдэд зориулсан мэдээлэл зөвлөгөө өгөх “Өмнөговь сувилахуй” цахим хуудас ажиллуулах | Тайлан | Иргэдэд сувилахуйн тусламж үйлчилгээ, асаргаа сувилгааны мэдлэг мэдээлэл олгоно. | ЭМГ | ЭМБ-ууд | Жилийн турш | - |
| 1.6 | 6. Орон нутагт хэрэгжиж байгаа дэд хөтөлбөрүүдийн багт ажиллах сувилагч,тусгай мэргэжилтний ололцоог нэмэгдүүлэх | Тайлан | НЭМ-ийн чиглэлээр | ЭМГ | ЭМБ-ууд | Жилийн турш | Орон нутгийн төсөв |
| **Үйл ажиллагааны чиглэл II** | | Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах | | | | | |
| 2.1 | ***Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах.*** | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 7. Сувилахуйн тусламж үйлчилгээний эрсдэлийн үнэлгээний төлөвлөлт хийх, хариу арга хэмжээ авч ажиллах | Зохион байгуулсан арга, хэмжээний тоо, төрөл | Алдаа эрсдэл гарахаас урьдчилан сэргийлэгдэнэ. | ЭМБ-ууд | ЭМГ | Жилийн турш | - |
| | 8. Сувилахуйн тусламж үйлчилгээ, эрүүл мэндийн чанар аюулгүй байдал сайжруулах ажлуудыг зохион байгуулах | Зохион байгуулсан арга, хэмжээний тоо, төрөл | Улирал бүр чанарын үзүүлэлт ахисан байна. | ЭМБ-ууд | ЭМГ | Жилийн турш | ЭМБ-ууд зардлыг хариуцах |
| | 9. Сувилахуйн тусламж үйлчилгээний сэтгэл ханамжийг сайжруулах олон талт арга хэмжээг зохион байгуулах үнэлгээ, үр дүнг тооцох | ЭМБ-ууд үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжид судалгаа хийсэн үнэлгээ | Улирал бүр үнэлгээг нэгтгэж үр дүнг гаргана. | ЭМБ-ууд | ЭМГ | Жилийн турш | - |
| | 10. Сувилахуйн тусламж үйлчилгээний стандарт удирдамжуудын хэрэгжилтийг сайжруулах сургалт зохион байгуулах | Хөтөлбөр, тайлан | 4 | ЭМБ-ууд | ЭМГ | Улиралд 1 удаа | - |
| | 11. Сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлэгчдийн ёс зүй, харилцааны соёлыг сайжруулах сургалтыг тогтмолжуулах | Хөтөлбөр, тайлан | 4 | ЭМБ-ууд | ЭМГ | Улиралд 1 удаа | - |
| | 12. Сэргээн засах сувилахуйн тусламж үйлчилгээг өргөжүүлж, ХБИ-дэд хүрч үйлчлэх ажлуудыг зохион байгуулах | Тайлан | Зохион байгуулсан арга, хэмжээний тоо, төрөл | ЭМБ-ууд | ЭМГ | Жилийн турш | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2 | ***Үйлчлүүлэгч төвтэй, нотолгоонд суурилсан сувилахуйн тусламж үйлчилгээг хөгжүүлэх*** | | | | | | |
| | 13. Сувилахуйн судалгааны тэргүүлэх чиглэлд заасан сэдвээр судалгааны ажил хийх, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах | Хийгдсэн судалгааны тайлан | 1 | ЭМБ-ууд | ЭМГ | 5 сард | Төсөл хөтөлбөр |
| | 14.Төрөлжсөн нарийн мэргэжлийн сувилагч, тусгай мэргэжилтнийг бэлтгэх ажлыг зохион байгуулах | Суралцагчийн тоо | 1 | ЭМГ | ЭМБ-ууд | 3, 9 сар | Улсын төсөв |
| | 15. Шинэ сувилагч, тусгай мэргэжилтэн, оюутнуудад ажлын байрны сургалт, дадлага хийлгэж,мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэхэд дэмжин ажиллах | Сургалтын хөтөлбөр Тайлан | Дадлагажсан сувилагч, тусгай мэргэжилтний тоо<br><br>Дадлага хийсэн оюутны тоо | ЭМБ-ууд | ЭМГ | 6-12 сард | - |
| | 16. Сувилагч , тусгай мэргэжилтнүүдийн мэргэжлийн зэрэг горилох, ахиулах, батагтах шалгалтад хамруулах, дэмжин туслах | Хамрагдсан тоо | Болзол шалгуур хангасан сувилагч, тусгай мэргэжилтэн хамрагдана. | ЭМБ-ууд | ЭМГ | 5 сар | - |
| | 17. Сувилахуйн бакалаврын орон нутгийн анги бүрдүүлэн хичээллүүлэх | Суралцагчийн тоо | 10 | АЗДТГ, НБХ ЭМГ | ЭМБ-ууд | 3, 9 сар | Улсын төсөв |
| 2.3 | ***Сувилахуйн тусламж, үйлчилгээнд шинэ технологи нэвтрүүлэх, чанарын тогтолцоог бэхжүүлэх*** | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 22. Үйлчлүүлэгчийг хүлээн авах, эмнэлэг хооронд, тасаг хооронд шилжүүлэх, эмнэлгээс гаргах, шаардлагатай мэдээлэл, сувилахуйн зөвлөгөө өгөх, бичиг баримтын бүрдэлтийг шуурхай болгох ажлын арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжүүлэлтийг сайжруулж ажиллах | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, төрөл | Байгууллага бүр 2-оос дээш ажил | ЭМБ-ууд | ЭМГ | 5, 11 сар | - |
| Үйл ажиллагааны чиглэл III | | Сувилахуйн хүний нөөцийг нэмэгдүүлэх, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх | | | | | |
| 3.1 | ***Сувилагчийн ажлын ачааллыг бууруулах, хүний нөөцийн зохистой харьцааг бүрдүүлэх*** | | | | | | |
| | 23. Сувилагч, тусгай мэргэжилтнүүдийн дутагдалтай байгаа газруудад тэтгэлэгт хамруулан хүний нөөцийг нэмэгдүүлэх | Шинэ сувилагч, эх баригчийн орон байрны асуудлыг шийдвэрлэн, тэтгэлэгт хамруулсан байна. | БОЭТ -10<br>Анхан шатны эмнэлгүүд 1-3 | ЭМБ-ууд | ЭМГ | 1-12 сар | - |
| | 24. Тасгийн ахлах сувилагчийн ажлын байр, сувилагчийн постыг байгууллагын дотоод сүлжээнд холбогдсон компьютероор хангах | Цахим сүлжээнд холбогдсон постын тоо | БОЭТ-5<br>Анхан шатны ЭМБ-ууд- 1 | ЭМБ-ууд | ЭМГ | 1-12 сар | Төсөл хөтөлбө р |
| 3.2 | ***Сувилагчийн ажиллах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх*** | | | | | | |
| | 25. Сувилахуйн тусламж үйлчилгээнд шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийн хангалтын судалгааны сан бүрдүүлж, хангалтыг | Судалгааны сан, хангалтыг сайжруулсан байдал | Байгууллага бүр хангалтыг 10% сайжруулах | ЭМБ-ууд | ЭМГ | 5, 11 сар | Төсөл хөтөлбө р |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 34.Хүний нөөцийг нэмэгдүүлэх асуудлаар байгууллагын төсөвт байнга нэмж суулгуулах саналыг хүргүүлэх | Нэмэгдсэн сувилагчийн тоо | ЭМБ бүр | ЭМБ-ууд | ЭМГ | 1, 7 сар | - |
| | 35. Сувилахуйн тусламж үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр төсөл,хөтөлбөр хэрэгжүүлэх | Төсөл, хөтөлбөрийн тоо | ЭМБ бүр 1 | ЭМБ-ууд | ЭМГ | 1-12сар | - |
| 4.4 | ***Сувилахуйн тусламж үйлчилгээнд гадаад, дотоод хамтын ажиллагааг дэмжин хөгжүүлэх*** | | | | | | |
| | 36. Байгууллага, нэгж дотроо болон бусад байгууллагуудын явуулсан нийтийг хамруулсан ажлуудын хамрагдалтыг сайжруулж багаар ажиллах чадварыг хөгжүүлэх | Зохион байгуулагдсан ажлын тоо<br><br>Хамрагдалтын байдал | ЭМБ бүр | ЭМБ-ууд | ЭМГ | Жилийн турш | - |
| | 37.Сувилагч,тусгай мэргэжилтнүүдийн байгууллагуудад туршлага судлах үйл ажиллагааг дэмжих | Хамрагдсан ахлах сувилагчийн тоо | ЭМБ бүр | ЭМГ | ЭМБ-ууд | Жилийн турш | Төсөл хөтөлбөр |
| | 38. Ажлын байрны зайн сургалт, хурал, хэлэлцүүлгийг төлөвлөгөөтэйгөөр зохион байгуулж хэвшүүлэх | Зохион байгуулсан ажлын тоо | ЭМБ тус бүр 5-с доошгүй | ЭМГ | ЭМБ-ууд | Жилийн турш | - |
| | 39. Сувилагчдыг олон улсын хурал, сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах | Хамрагдсан мэргэжилтнүүдийн тоо | 2 | ЭМГ | ЭМБ-ууд | Жилийн турш | Төсөл хөтөлбөр |

-0000-